



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/114

Арвайхээр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.6, Засгийн газрын 2015 оны “Жагсаалт батлах тухай” 336 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт”-ын 8.8 дахь хэсэг, аймгийн Онцгой комиссын 2023 оны өргөтгөсөн 03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Онцгой комиссын өргөтгөсөн хуралдаанаар өвөлжилтийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээгээр 14 сум эрсдэлийн түвшин их, 5 сум дунд эрсдэлтэй гарсан тул өвөлжилтийг хохирол багатай даван туулах зорилгоор Баянгол, Богд сумдаас гадны аймагт оторлоогүй үлдсэн малчин өрхүүдэд хямдралтай үнээр олгох өвсний үнийн зөрүү 6,800,000 (зургаан сая найман зуун мянга) төгрөгийн зардлын хуваарилалтыг хавсралтаар баталсугай.

2. Өвс нийлүүлсэн аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээ байгуулж, өвс тэжээлийн чанар, баглаа боодол, гарал үүсэл зэрэгт хяналт тавьж, хуваарилалт хийж, гэрээ байгуулахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т үүрэг болгосугай.

3. Дээрх зардал болох 6,800,000 (зургаан сая найман зуун мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0192

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар
сарын 07-ны өдрийн 114 дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

| д/д | Сумын нэр | Сумдад олгох өвсний тоо | Өвсний нэг бүрийн үнэ (мянган төгрөг) | Нийт үнэ (мянган төгрөг) | Өвс нийлүүлэх иргэн, аж ахуйн нэгжийн нэр |
|-----|-----------|-------------------------|---------------------------------------|--------------------------|-------------------------------------------|
| 1 | Баянгол | 700 | 8.0 | 5600,0 | Э.Өсөхбаяр |
| 2 | Богд | 150 | 8.0 | 1200,0 | Түвшин хангай ХХК |
| | | 850 | | 6800,0 | |

-оОо-